



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/65

Шивээговь сум

Тооллого зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.в, 20 дугаар зүйлийн 20.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/173 дугаар “Тооллого зохион байгуулах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2024 оны эхний хагас жилийн мал тооллогыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Мал тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Комиссын дарга: (Засаг даргын орлогч дарга)
- Гишүүд: (1 дүгээр багийн Засаг дарга)
- (2 дугаар багийн Засаг дарга)
- (Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Аймгийн Мал эмнэлгийн газрын Нян судлалын шинжээч эмч
- (Соёлын төвийн Орон нутаг судлах танхимын ажилтан)
- Нарийн бичгийн дарга: (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

3.Тооллогын ажилд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

4.Тооллогын ажилд зарцуулагдах 151,040 (нэг зуун тавин нэгэн мянга дөч) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүгийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

5.Тооллого явуулахтай холбогдуулан түүврээр сонгогдсон өрхийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, товлосон хугацаанд, зохих журмын дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг комиссын даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

125

Сумын Засаг даргын 2024 оны
05-р сарын 20-ны өдрийн
11/05 дугаар захирамжийн хавсралт



“ 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН МАЛ ТООЛЛОГО ”-ЫН
АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/Д	Материалын нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ
1	АИ-92 шатахуун	59	Литр	2560	151,040
НИЙТ					151,040